

НИЙГМИЙН АЖИЛТАН БЭЛТГЭХ АЖЛЫГ ЭРЧИМЖҮҮЛЭХ АСУУДАЛД

Ч.Дагвадорж Нийгмийн Хамгаалал
Хөдөлмөрийн Яам, хэлтсийн дарга, доктор /Ph.D/

Судлаач Ч. Дагвадорж нь Япон сангийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа “Япон, Монголын нийгмийн хамгааллын салбарын харьцуулсан судалгаа”-ны ажлын урьдчилсан үр дүнд үндэслэн нийгмийн халамжийн салбарын нийгмийн ажилтан бэлтгэх ажлыг эрчимжүүлэх талаар өөрийн үзэл бодлыг энэ ажилдаа тусгажээ.

Энэхүү бүтээлд нийгмийн ажилтны үүрэг, хариуцлага, хэрэгцээ, шаардлагын талаар дэлгэрэнгүй авч үзсэнээс гадна хэнд, ямар шалгуураар нийгмийн ажил хийх “эрх” болон “итгэмжлэл” олгодог, энэ нь манай улсын хувьд хэрхэн хэрэгждэгийг судалж харьцуулсан үнэлэлт дүгнэлт өгсөн байна.

Эцэст нь нийгмийн ажилтныг бэлтгэх сургалтын агуулга, стандартыг Япон болон Монгол улсын жишээн дээр авч үзээд манай улсын сургалтын тогтолцоо, нийгмийн ажилтны талаарх ерөнхий ойлголт, тэдний мэргэжлээрээ ажиллаж буй байдал зэрэгт шүүмжлэлтэй хандаж өөрийн санал, зөвлөмжийг дэвшүүлсэн байв.

Нийгмийн ажилтны талаарх асуудал нь манай улсын хувьд харьцангуй шинэлэг асуудал бөгөөд судлаач энэ талаар өөрийн судалж мэдсэн туршлагыг та бүхэнтэй дэлгэрэнгүй хуваалцаж байгааг сонирхон уншина уу.

Acknowledgement:

This paper was done during the stay at Japan College of Social work under Japan Foundation Fellowship Program

Япон сангийн Тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд хийгдэж байгаа “Япон, Монголын нийгмийн хамгааллын салбарын харьцуулсан судалгаа”-ны ажлын урьдчилсан дүнг үндэслэн нийгмийн халамжийн салбарын нийгмийн ажилтан бэлтгэх асуудлаар энэхүү өгүүллэгийг нийтлүүлж байна.

Нийгмийн халамжийн үйлчилгээний үр ашиг, чанарыг дээшлүүлэх, хамрах хүрээг зөв тогтооход хариуцлагатай, чухал үүргийг нийгмийн ажилтан гүйцэтгэдэг. Нийгмийн ажилтнаас үйлчилгээний чанар, үр ашиг, эмзэг бүлгийнхний амьдрал хамаардаг. Иймээс нийгмийн ажилтныг сургах, дадлагажуулах ажил нэн чухал ач холбогдолтой гэдгийг дэлхийн улс орнууд хүлээн зөвшөөрч, нийгмийн халамжийн боловсон хүчин бэлтгэдэг тогтолцоог бий болгон төлөвшүүлж байна.

Японд нийгмийн ажилтан гэдэгт тусгайлан бэлтгэгдсэн, зохих байгуулагаар итгэмжлэгдсэн, нийгмийн ажил эрхлэх эрх авсан, халамжийн үйлчилгээний салбарт ажиллагсдыг хамруулж байна. Эдгээр нийгмийн ажилтнууд ихэвчлэн халамж, асрамж, сувиллын газарт ажиллаж ахмад настан, тахир дутуу иргэдийн эрүүл мэндийн судалгаа гаргах, эрт өтлөлт, өвчлөлтөөс урьдчилан сэргийлэх талаар сурталчлах, мэргэжлийн зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх эмчилгээ хийх зэрэг дэмжлэг тусалцаа үзүүлэх үйлчилгээг эрхэлж байна. Түүнчлэн нийгмийн ажилтнууд нь эмзэг бүлгийн хүмүүсийн хэрэгцээг тодорхойлохоос эхлээд

тэднийг нийгмийн үйлчилгээнд хамруулах, амьжиргаагаа дээшлүүлэхэд чухал үүрэгтэй.

Нийгмийн ажилтнууд хүний хэрэгцээг хоол хүнс, өргөн хэрэглээний барааны хүртээмж, гэр орон, эрүүл мэндийн үйлчилгээ, боловсрол, нийгмийн болон байгаль орчны үйлчилгээ, амралт, алжаал тайлах, орчны тохь тухтай байдал, тээврийн хэрэгслийн боломжтой байдал зэрэг үзүүлэлтээр тодорхойлж нийгмээс зайлшгүй үйлчилгээ авах шаардлагатай иргэдийг тодруулахад онцгой үүрэг гүйцэтгэдэг. Зарим оронд нийгмийн үйлчилгээний талаар нэгдсэн мэдээлэл түгээдэг цэг ажиллуулж ахмад настнууд, тахир дутуу иргэд, орлого багатай иргэд, нялх хүүхэдтэй эхчүүдийн ажлыг ихээхэн хөнгөвчилж, өөрт хэрэгтэй мэдээллээ цаг алдалгүй авч байх боломжоор хангах үүргийг нийгмийн ажилтнууд гүйцэтгэж байна. Мөн хоол цай хийж хооллох, орон байр цэвэрлэх, усанд оруулах, хувцаслах, салхинд гаргах, ариун цэвэр сахиулах, дэлгүүрээс шаардлагатай зүйлийг авч өгөх, сэтгэл санааны дэм үзүүлэх, эмчлэх, сувилах, хамт байж элэгсэг хандах, тэтгэврийг авчирч өгөх, гадуур ажлыг эмхлэх, мэдээлэл авах, утсаар ярих, хөнгөн хөдөлмөр эрхлэх зэрэгт туслалцаа үзүүлэх үйлчилгээг гэрийн туслах, сайн дурын идэвхтэн, нийгмийн үйлчилгээний ажилтнууд гүйцэтгэж байна.

Энэ бүхнээс үндэслээд “Нийгмийн ажилтан “ гэдэгт нийгмийн салбарт ажиллах мэдлэг боловсролтой, ажлын дадлага туршлагатай, зохих байгууллагаар шалгуулж, итгэмжлэл, эрх авсан ажилтнуудыг хамруулдаг байна. Япон зэрэг зах зээлийн харилцаанд бүрэн шилжсэн, өндөр хөгжилтэй, төрийн болон хувийн өмчийн байгууллагууд нийгмийн халамжийн салбарт үйлчилдэг орнуудад нийгмийн ажилтанг бэлтгэх систем төлөвшиж, зохих шалгуурыг хангасан мэргэжилтэн , байгууллагууд халамжийн үйл ажиллагааг эрхлэх эрхтэй болдог байна.

Нийгмийн ажилтан бэлтгэх сургалтын тогтолцоог бүрдүүлэхдээ нийгмийн халамжийн үйлчилгээ сайн хөгжсөн, үр дүн нь тодорхой болсон орнуудын туршлагыг өөрийн орны онцлогт нийцүүлэн, нэвтрүүлэх шаардлага манай орны хувьд чухал ач холбогдолтой. Тухайлбал, Япон улсад нийгмийн ажилтны сургалтыг дараах шатлалаар зохион байгуулдаг туршлагыг манай орны нөхцөлд аажмаар хэрэглэх боломжтой хэмээн үзэж байна.

Үндсэн мэргэжил олгох сургалт - 2- 4 жилийн сургалттай, 6-13 төрлийн мэргэших хичээл үзэх хөтөлбөртэй их сургууль, коллежууд нийгмийн хамгааллын чиглэлийн мэргэжилтэн бэлтгэж байна. Эдгээр сургуулийг төгссөн хүмүүс 1-2 жил үндсэн нэгжид ажиллаж дадлага эзэмшсний дараа шалгалтанд орж, нийгмийн ажилтны итгэмжлэл авах эрхтэй болдог.

Дипломын дараах сургалт - Богино хугацааны, тусгай хөтөлбөртэй сургалт нь өөр чиглэлээр мэргэжил эзэмшсэн хүмүүст нийгмийн хамгааллын мэргэжил олгох зорилготой бөгөөд энэ сургалтыг дүүргэсний дараа нийгмийн ажилтны итгэмжлэл олгох үндэсний шалгалтанд орох эрхтэй болно.

Магистрийн зэрэг олгох сургалт - Бакалаврын зэрэгтэй, нийгмийн халамжийн чиглэлээр ажиллаж байгаа хүмүүст зориулсан нэг жилийн хугацаатай сургалт юм. Суралцагчид нь ахмад настан, тахир дутуу иргэдэд үзүүлэх халамж, гэр бүл, удирдлага, зохион байгуулалт зэрэг чиглэлээр суралцдаг.

Докторын зэрэг олгох сургалт - Нийгмийн хамгааллын чиглэлээр магистрийн зэрэг бүхий хүмүүсийг элсүүлэн сургадаг. Зорилго нь их дээд сургууль, коллежид өндөр мэргэжлийн багш нар, судлаачдыг бэлтгэхэд чиглэгддэг.

Японы Эрүүл мэнд, хөдөлмөр, хамгааллын яамнаас 1988 оноос эхлэн тусгай хөтөлбөрөөр зохион байгуулдаг сургалтанд хамрагдаж амжилттай дүүргэсэн хүмүүсийг үндэсний хэмжээнд явагддаг шалгалтанд хамруулж тэнцвэл “Итгэмжлэгдсэн нийгмийн ажилтан” гэрчилгээ, ажил, үйлчилгээ явуулах эрх олгодог байна.

Японы нийгмийн ажилтнуудыг итгэмжлэхдээ дотор нь нийгмийн ажилтан, нийгмийн үйлчилгээний ажилтан гэж 2 ангилдаг.

Нийгмийн ажилтан гэж ямар нэгэн шалтгаанаар амьдралын хүнд нөхцөлд байгаа хүмүүс, тахир дутуу иргэдийг дэмжих, зөвлөлгөө өгөх талаар мэргэжсэн, сэтгэл зүй, ёс суртахууны хувьд бэлтгэгдсэн ажилтанг хэлдэг. Итгэмжлэх шалгалтанд дараах болзлыг хангасан мэргэжилтнүүд ордог. Үүнд:

а. 4 жилийн сургалттай, 13 төрлийн хичээлээр мэргэшдэг нийгмийн хамгааллын мэргэжлийн их, дээд сургууль буюу хүүхэд, ахмад настан, тахир дутуу иргэдийг хамгаалах мэргэжлээр 5 жилийн сургалттай сургууль төгссөн бол шууд,

б. 13 төрлийн хичээлээр мэргэшдэг, 3 жилийн сургалттай нийгмийн хамгааллын мэргэжлийн коллеж төгссөн бол 1 жил, 2 жилийн сургалттай коллеж төгссөн бол 2 жил үндсэн нэгжид ажилласны дараа,

в. 4 жилийн сургалттай, 6 төрлийн хичээлээр мэргэшдэг нийгмийн хамгааллын мэргэжлийн их, дээд сургууль төгссөн бол богино хугацааны (6 сарын) сургалтанд хамрагдсны дараа,

г. 6 хичээлээр мэргэшдэг, 3 жилийн сургалттай нийгмийн хамгааллын мэргэжлийн коллеж төгссөн бол 1 жил, 2 жилийн сургалттай коллеж төгссөн бол 2 жил үндсэн нэгжид ажиллаад богино хугацааны сургалтанд хамрагдсны дараа,

д. 4 жилийн сургалттай нийгмийн хамгааллын бус мэргэжлийн их, дээд сургууль төгссөн бол 1 жилийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсаны дараа,

е. 3 жилийн сургалттай нийгмийн хамгааллын бус мэргэжлийн коллеж төгссөн бол 1 жил, 2 жилийн сургалттай коллеж төгссөн бол 2 жил нөхөн сэргээх нэгжид ажиллаад 1 жилийн мэргэшүүлэх сургалтанд хамрагдсаны дараа тус тус үндэсний шалгалтанд орох болзлыг хангадаг байна.

Нийгмийн үйлчилгээний ажилтан гэж эмзэг бүлгийн хүмүүсийг асрах, сувилах, тэдэнд тусламж, дэмжлэг үзүүлэх асуудлаар мэргэжиж бэлтгэгдсэн, зохих журмын дагуу шалгуулж үйлчилгээ эрхлэх эрх авсан хүмүүсийг хэлдэг байна. Нийгмийн үйлчилгээний ажилтанг дараах чиглэлээр бэлтгэдэг.

Өндөр настан, тахир дутуу хүмүүсийг асрах халамжийн ажилтан. Хуулийн дагуу тахир дутуу иргэд, өндөр настанг асрах мэргэшил олгодог мэргэжлийн итгэмжлэгдсэн сургуулийг төгссөн хүмүүст “Бүртгэгдсэн халамжийн ажилтан” гэрчилгээ болон ажил үйлчилгээ явуулах эрх олгодог байна.

Хүүхэд асрагч - Япон улсад 40-өөд жилийн өмнөөс хүүхэд асрагч нарыг 2 жилийн сургалттай коллежоор бэлтгэж байна.

Нийгмийн үйлчилгээний ажилчдад дараах болзлыг хангасан нөхцөлд итгэмжлэл олгодог. Үүнд:

а. Ахлах сургууль төгсөөд 2-4 жилийн нийгмийн үйлчилгээний чиглэлээр мэргэшүүлэх сургалттай сургууль төгссөн бол шууд,

б. Нийгмийн хамгааллын дээд сургууль, нийгмийн ажилтны тусгай сургалт, сувилагчийн багшийн сургууль дүүргэсэн бол 1 жилийн мэргэшүүлэх сургалт дүүргэсний дараа,

в. Тусгай сургалттай ахлах сургууль, сувилагчийн мэргэжлийн сургууль төгсөөд 3 – аас доошгүй жил ажилласан бол тус тус үндэсний шалгалт өгч итгэмжлэл авах болзлыг хангадаг байна.

Харин манай оронд нийгмийн ажил гэдэгт юуг, нийгмийн ажилтан гэдэгт хэнийг хамруулан үзэх нь ойлгомжгүй байгаагаас боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, хөдөлмөр, соёл, урлаг зэрэг олон салбарт ажиллагчдыг хамруулан ойлгох хандлага ажиглагдаж байна. Тэр ч байтугай нийгэм, улс төрийн зүтгэлтнүүд, нийгмийн үйлчилгээ үзүүлдэг төрийн бус байгууллагын ажилтнууд, нийгэм судлаачид өөрсдийгөө “Нийгмийн ажилтан” гэж нэрлэх тохиолдол гарч байна.

Манай улсын нийгмийн халамж, үйлчилгээний салбарт 700 гаруй хүн ажиллаж байгаа боловч ихэвчлэн эдийн засагч, нягтлан бодогч, багш, эмч, инженер зэрэг нийгмийн ажлын мэдлэг боловсрол, мэргэжлийн бэлтгэлгүй, нийгмийн эмзэг бүлгийнхэнтэй харьцах талаар ажлын туршлага багатай хүмүүс байна. Асрамжийн газрын асрагч, сувилагч, багш, сайн дурын ажилтнууд нийгмийн шинж чанартай аливаа асуудал, бэрхшээл гарахад хэрхэн шийдвэрлэх талаар мэдлэггүй, дэмжиж туслах, асарч сувилах үүрэг гүйцэтгэхээсээ илүү хянах, шалгах үүрэгтэй ажиллаж байгаа нь судалгаагаар тогтоогдлоо.

Нийгмийн асрамж, халамжийн үйлчилгээнд эмнэлгийн загвар хэрэглэж хүмүүсийн материаллаг болон эрүүл мэндийн эрэлт хэрэгцээг анхаарч байгаагаас бус тэдний сэтгэл санаа, оюуны эрэлт хэрэгцээ болон нийгмийн бусад хүчин зүйлүүдийг орхигдуулахад хүрч байна.

Хүүхдийн асрамжийн байгууллагад ажиллаж байгаа ихэнх ажилчид нийгмийн ажил, тухайлбал, хүүхдийн хөгжил, хүүхдийн сэтгэл судлал болон өвөрмөц сургалтын аргын талаар ойлголт багатай байна. Иймд асрамжийн байгууллагын хэмжээ зориулалт болон асруулагчдын байдлаас хамааран тэднийг зохих хэмжээний давтан сургалтанд хамруулах хэрэгтэй болжээ. Эндээс манай улсад нийгмийн халамжийн мэргэшсэн ажилтан бэлтгэх ажил хоцрогдонгүй байна гэж дүгнэж болох юм.

Өнөөгийн нөхцөлд хүмүүнлэг, ардчилсан, иргэний нийгмийн шаардлага, захиалгад дүйцсэн нийгмийн жинхэнэ ажилтны дүр төрх, имиж, шалгуур, стандартыг бий болгон зүгшрүүлэх нэн чухал асуудлуудыг нэг болж байна.

Манай улсын хувьд одоогоор УБИС-д нийгмийн ажилтан бэлтгэх нэг анги, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн Хүмүүнлэгийн сургуульд нийгмийн халамж зүйн анги, зарим хувийн дээд сургууль, коллежид нийгмийн ажилтны анги нээж оюутан элсүүлдэг боловч сургалтын нэгдсэн агуулга, стандарт зүгшрээгүй, хэрэглэгч яам, байгууллагатай ажлын уялдаа, холбоо хангалтгүй байна. Тухайлбал, УБИС, ШУТИС хоёр нийгмийн ажилтны мэргэжлээр хэд хэдэн удаагийн төгсөлт хийж, бакалаврын түвшний мэргэжилтэн бэлтгэсэн боловч төгсөгчдөөс нийгмийн халамжийн байгууллагуудад хуваарилагдан ажиллаагүй шахам байна. Мөн сургуулийн, хорооны болон сумын “нийгмийн ажилтан” гэсэн ажлын байр бий болж олон зуун хүн ажиллаж байгаа боловч ажил үүргийн хуваарь тодорхойгүй, мэргэжлийн түвшин

хангалтгүй зэргээс тоо мэдээлэл цуглуулах, захирлын туслах, сурагчдын дотуур байрны багшийн үүрэг гүйцэтгэх зэрэг үндсэн бус үйл ажиллагаанд ихэнх цагаа зарцуулах байдал ажиглагдаж байна.

Иймээс дотоод, гадаад нөөц бололцоонд түшиглэж бусад орны ололт, амжилтыг үндэсний онцлогт тохируулан нийгмийн ажилтанг бэлтгэх, давтан сургах тогтолцоог бий болгох шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Энэ асуудлыг оновчтой шийдвэрлэхийн тулд эхний ээлжинд мэргэжилтэн бэлтгэж байгаа сургалтын байгууллага, тэдний сургалтын хөтөлбөрийг атесстатчилж, мэргэжил, ур чадварын ялгавартайгаар зөвшөөрөл олгож, гүйцэтгэлд нь хяналт тавих систем тогтоох нь чухал.

Нийгмийн халамжийн салбарт ажиллагсдыг мэргэжлийн сургууль, мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамруулах замаар нийгмийн ажил эрхлэх чадварыг сайжруулж, зохих шалгуур үзүүлэлтүүд, нөхцөл, болзлыг хангасан ажилтанг үндэсний шалгаруулалтанд хамруулан “итгэмжлэл”, үйлчилгээ эрхлэх “эрх” олгох системийг бүрдүүлэх шаардлага ч тавигдаж байна.